

## ШҮҮМЖ, НОМ ЗҮЙ

**МАОИЗМ И НАЦИОНАЛЬНЫЙ ВОПРОС**

УБ, 1980, 388 х.

Улаанбаатарт болсон «Маоизм ба үндэстний асуудал» сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний симпозиумд тавигдсан илтгэлийг эмхэтгэсэн энэхүү номд БНМАУ-ын ШУА-ийн дэд ерөнхийлөгч Ш. Бира «Маоизм ба Хятад дахь үндэстний асуудал», ЗХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн М. И.Сладковский «Нэгдмэл хятад үндэстний тухай их хан үндэстний номлол», В.И.Потапов (ЗХУ) «Үндэстний цөөнхийн районуудад хятадын удирдагчдаас явуулж буй эдийн засгийн бодлого», Л.М.Гудошниковын «Үндэстний төрийн байгуулалт ба үндэстний автономит бодлогын тухай асуудал дахь хятадын удирдагчдын их гүрний үндсэрхэх үзэл, Анджей Халкимарскийн (БНПАУ) «Хятад дахь үндэстний цөөнхийг устгах, хятадчилах зарим асуудлын тухай», Карл Куркагийн (БНСЧСУ) «Өнөөгийн Хятадын түрэмгийллийн түүхэн эх сурвалжийн асуудалд» зэрэг хятадын удирдагчдын үндэстний асуудлын талаар явуулж байгаа харгис бодлогыг бүх талаар илчилсэн олон илтгэл оржээ.

Хятадад хувьсгал ялснаас хойш үндэстний асуудлыг зөвөөр шийдвэрлэх нь эрхэм чухал асуудлын нэг байлаа. Хятадад оршин сууж байгаа үндэстний цөөнх нь угсаатны гарлаараа хөрш зэргэлдээ орших ард түмэнтэйгээ илүү ойр байжээ. Эдгээр ард түмний соёл хятадын соёлтой эртнээс төдийлөн холбоотой байгаагүй, харин салангид хөгжиж иржээ. Ийм нөхцөлд шинэ хятадын удирдагчид цөөн тоот үндэстнүүддээ өөртөө засах эрх олгох тухай тунхагласан юм. Гэвч эдгээр ленинч зарчим их гүрний дээрэнгүй бодлогод нь нийцэхгүй байсан учир маогийнхан үндэстний буюу «районы» автономи гэгчийг гаргаж тэр нь үнэн хэрэг дээрээ бага үндэстнүүдийг устгах, салган бутаргах, өөрөө засан тогтнох эрхгүй болгох зорилготой байжээ. (24-р тал).

Бээжингийн удирдлага хятад бус үндэстний оршин сууж байгаа нутгийг хэд хэдэн автономит районд салган хувааж, хэрэг дээрээ хятад мужийн адил захиргаа тогтоож өөрийн үндсэрхэх дээрэнгүй бодлогоо хэрэгжүүлэх анхны практик алхам хийсэн билээ.

«Соёлын хувьсгал» маогийнхны үндсэрхэг үзэлтнүүдийн жинхэнэ мөн чанарыг харуулав. Тэд «Умардын аюул» гэгчийг зохион хүн амыг сүрдүүлж үндэстний цөөнхийг мөрдөн хавчиж эхлэв. Маогийнхны их гүрний үндсэрхэг энэ бодлого үндэстний автономийг устгах, эдийн засгийн хямрал, ард түмний амьдралын түвшнийг эрс доройтуулахад хүргэсэн юм.

«Соёлын хувьсгал» маогийн үндэстний бодлогын хямралыг тод харуулсан билээ. (30-р тал). Их гүрний үндсэрхэг үзэл, түүний үзэл суртлын үндэс манай эриний өмнөх VIII зууны үед бүрэлдэн тогтсон ба Хятад төвийн үзэл бүрэлдэн тогтох эхлэл нь төрийн байгуулалтын хөгжлийн онцлогоос шалтгаалжээ. Хятад бус ард түмнүүдээ бодвол хан үндэстэн соёлын хувьд давуу хөгжилтэй гэдэг үзэл хятадын эрх баригчдын их хан үндэстний үндсэрхэг үзлийг сэргээжээ. Энэ үзэлд Кунз болон ленистүүдийн ёс суртахууны сургаал эх суурийг нь тавьсан юм.

Кунзийн номнолын агуулга нь нийт улс түмнийг хятадууд, бусад бүдүүлэг ард түмэн хэмээн ангилжээ. Хятадууд хөрш ард түмнийг бодвол зохион байгуулалттай, угсаатны хувьд бүрэлдэн тогтсон ёс суртахуун, соёлын хувьд тэднээс давуу хэмээн үзэж байв. Кунзийн үзэл санааг дэмжигч ленистүүд «чадал муутай улс нь хөрш зэргэлдээ оронд цохигддог» учир улсын хүчин чадал нь дайтахаас харьцангуйгаар шалтгаалах шинэ үзэл санааг гаргажээ. Иймд эзлэн түрэмгийлэх бодлого Хятадын улс төрийн албан ёсны бодлогын хэмжээнд дэвшигдэн тавигдсан байна.

Хятадын нийгэм хөгжих тусам гадаад бодлогын номлол үргэлжлэн хөгжиж, түүний дотор хятад төвийн үзэл, үзэл суртлын гол нь болон хөгжжээ.

Олон зуун жилийн турш уламжлагдан ирсэн үндсэрхэг үзэл хүмүүсийн оюун сананд хадгалагдаж, маоизмын үндэстний бодлогын зарчим бүрэлдэн тогтох явдалд шууд нөлөөлсөн нь дамжиггүй.

Өнөөгийн хятадын удирдагчдаас улс төрийн зарим хуучин зарчмыг шүүмжилж байгаа нь их гүрний үндсэрхэг үзэл улам бүр нарийн хэлбэрт орсныг гэрчилж байна. Хятадын эртний түүх гуйвуулах явдал дээр суурилагдсан их хан үндэстний үндсэрхэг үзлийн шинэ номлол гарган хэрэгжүүлж буй цаг үетэй бид хэрэг дээрээ тулгараад байна (245-р тал).

Одоогийн хятад бус ард түмний материаллаг аж байдлыг Хятадын удирдагчдаас автономит районуудад явуулж байгаа эдийн засгийн бодлого тодорхойлж байна. 50-иад оны дунд үеэс Төвд, Өвөр Монгол, Синьзяньд орон нутгийн ард түмний бололцоо нөхцөлийг үл харгалзан хоршооллох ажлыг хүчээр яаравчлан хийсэн нь нуралтанд орж хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг эрс бууруулж тариачдын материаллаг амьдралын түвшинд муугаар нөлөөлжээ.

1958 онд маоистуудаас явуулж эхэлсэн «гурван улаан тугийн» балмад бодлого балран унасан нь 1960-аад оны эхний үед үндэстний районуудын эдийн засгийн хөгжилд саад тогтор болж бээжингийн удирдагчдын «онцгой чиг шугам»-ыг төрүүлсэн юм. Бээжингийн удирдагчид үндэстний цөөнх районуудыг зөвхөн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн түүхий эдийн эх булаг хэмээн үзэх болжээ.

Бээжингийн удирдагчид социалист бүтээн байгуулалтын зарчмаас ухарч, «их үсрэлт», «соёлын хувьсгал»-ын бодлого нь балран унаж, улс орныг цэрэгжүүлэх чиг шугамыг баримталж, социалист орнуудтай хамтран ажиллахаас татгалзсан нь үндэстний районуудын эдийн засгийн хөгжилд ихээхэн хохирол үзүүлэв. (136-137-р тал).

60-аад оноос ЗХУ болон бусад хөрш орнуудтай харилцах харилцаагаа хурцатгаж эхэлсэн үеэс автономит районууд «хилийн район» болон хувирав. Энэ нь эдгээр районуудын эдийн засгийн хөгжлийг саатуулах, түүхий эдээр нь юуны өмнө цэргийн салбарын үйлдвэрийг хангах район болгох зорилготой ажээ. Дээрх районуудын дайны зорилго бүхий эдийн засгийн тэгш биш хөгжил орон нутгийн ард түмний материаллаг амьдралын өсөлтийн явцыг удаашруулж байна. Хүн амын ихэнх нь хоцрогдсон хөдөө аж ахуйг эрхэлж байна. Хүн амыг улсын төвлөрсөн фондоор хангахгүй байгаа бөгөөд «өөрөө өөрийгөө хангах» өөрөөр хэлбэл «Дажайгийн арга» хэрэглэх зарчим үргэлжилсээр байна.

Мао Зэдун нас барсны дараа болон «дөрвийн бүлгийг» авч хаяснаас хойш хятадын удирдагчид үндэстний цөөнхийн асуудлын талаар улам бүр нарийн арга хэрэглэх болж хятад бус ард түмний эрх ашгийг хамгаалсан бодлого явуулж байгаа дүр үзүүлж байна. Гэвч эдийн засгийн хөгжлийн хувьд их хан үндэстний үндсэрхэг чиг шугам нааштай өөрчлөлт үзүүлсэнгүй. Маоизм үндэстний районуудын нийгэм-эдийн засгийн хоцрогдлыг арилгаж чадахгүйг практик нотолж байна. (143-р тал).

Бээжингийн удирдагчдаас үндэстний цөөнхийн талаар явуулж байгаа бодлого тэдгээр ард түмний эрх ашигт шууд харшилж байна. Хятад бус ард түмний нийгмийн амьдралыг хүчээр хятадчилах бодлогод дургүйцсэн төвд, синьзянь, өвөр монголын ард түмний эсэргүүцлийг бээжингийн удирдагчид зэвсгийн хүчээр дарж, эдийн засгийг нь өрөөсгөл болгож, аж амьдралыг нь доройтуулж улмаар хятад бус ард түмний түүх соёлыг гуйвуулан гутааж буй зэрэг нь их хан үндэстний дээрэнгүй үзлийн арга барил мөнийг уг номд тод томруун харуулжээ.

**Г. Зориг**